

**ДУНДГОВЬ АЙМГИЙН САЙНЦАГААН СУМЫН НУТАГТ ОРШИХ  
“ИДЭР МАКС” ХХК-ЫН ХАЙЛУУР ЖОНШНЫ УУРХАЙН 2024 ОНЫ  
БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТАЙЛАН**

/АШИГТ МАЛТМАЛЫН ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ДУГААР: MV-021876/  
/АЖ АХУЙН НЭГЖИЙН РЕГИСТРИЙН ДУГААР: 6471919

ХЯНАСАН:  
БОУАӨЯАМНЫ ХБӨБХГ-ЫН МЭРГЭЖИЛТЭН

/...../

БИЕЛЭЛТИЙГ ТАЙЛАГНАСАН:  
“ИДЭР МАКС” ХХК-ЫН ЗАХИРАЛ  
БАЙГАЛЬ ОРЧНЫ МЭРГЭЖИЛТЭН

  
/...../  
/...../

## ГАРЧИГ

|                                                                                                                                                    |    |
|----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|----|
| 1. ТОВЧ ТАНИЛЦУУЛГА .....                                                                                                                          | 3  |
| 2. ТӨСӨЛ ХЭРЭГЖИЖ БУЙ НАЗРЫН ТОВЧ МЭДЭЭЛЭЛ.....                                                                                                    |    |
| 3. ТӨСЛИЙН ГОЛ БОЛОН БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ<br>ТОДОРХОЙЛОЛТ .....                                                                         | 15 |
| 4. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ<br>БИЕЛЭЛТ, ҮНДСЭН ҮР ДҮН.....                                                             |    |
| 5. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ<br>ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ<br>БИЕЛЭЛТ.....                                                            |    |
| 6. НӨХӨН СЭРГЭЭХ АЖЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ.....                                                                                                  |    |
| 7. БИОЛОГИЙН ОЛОН ЯНЗ БАЙДЛЫГ ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛАХ АРГА<br>ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ .....                                                    | 28 |
| 8. НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭХ, НӨХӨН ОЛГОВОР ОЛГОХ АРГА ХЭМЖЭЭНИЙ<br>ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ.....                                                             | 29 |
| 9. ТҮҮХ, СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ<br>БИЕЛЭЛТ.....                                                                       | 30 |
| 10. ОСОЛ ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ.....                                                                                         | 31 |
| 11. ХОГ, ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ.....                                                                                          | 32 |
| 12. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨРИЙН БИЕЛЭЛТ .....                                                                                            | 35 |
| 14. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ<br>БИЕЛЭЛТИЙГ НӨЛӨӨЛЛИЙН БҮСИЙН ОРШИН СУУГЧДАД ТАЙЛАГНАХ<br>ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ<br>БИЕЛЭЛТ..... | 38 |
| 15. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХЭД ГАРСАН<br>НИЙТ ЗАРДЛЫН ХЭМЖЭЭ.....                                                        |    |
| 16. ДҮГНЭЛТ.....                                                                                                                                   |    |
| 17. ХАВСРАЛТУУД.....                                                                                                                               |    |

## 1. ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

Дундговь аймгийн Сайнцагаан, Өлзийт сумдын нутаг дахь “Уушиг уул-1” нэртэй 117.26 га талбайг хамарсан MV-021876 тоот ашиглалтын тусгай зөвшөөрлийг эзэмшигч “Идэр макс” ХХК нь 2019 онд байгуулагдсан, 100 хувийн дотоодын хөрөнгө оруулалттай компани юм.

Ордын нөөцийг ЭБМЗ-ийн 2020 оны 06 сарын 25-ны өдрийн ХХ-08-06 тоот дүгнэлт, АМГТГ-ын даргын 2020 оны 11 сарын 05-ны өдрийн Н/106 тоот тушаалаар Уушиг уул-1 жоншны ордын тооцоолсон нөөцийг В+С зэргээр 110.14 мян.тн хайлуур жоншны хүдрийн нөөцийг бүртгэсэн байна

### 1.1. Ерөнхий мэдээлэл

*Төслийн нэр:*

- Уушиг уул нэртэй хайлуур жоншны ордыг ил далд хосолсон аргаар ашиглах төсөл

*Төсөл хэрэгжүүлэх аж ахуйн нэгж, байгууллагын нэр:*

- “Идэр макс ” ХХК
  - Улсын бүртгэлийн дугаар: 9019097636
  - Регистрийн дугаар: 6471919

*Төсөл хэрэгжүүлэгчийн хаяг:*

- Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг, 15-р хороо, Үйлдвэр 36 , 52 тоот
- Утас: 99085352


*Уурхайн ашиглалтын технологи:*

- Хайлуур жоншны ордод Хүдэр хоршоолон нураах ашиглалтын системийг ашиглана.
- Уушиг уул-1 хайлуур жоншны орд нь 2 хүдрийн биетээс тогтох ба хүдрийн биет-1 нь кварц-флюоритын судал хэлбэрээр өргөргийн дагуу 330м урттай,хүдрийн биет-2 нь кварц-флюоритын судал бөгөөд хүдрийн биет-1-ээс баруун тийш 50.0-70.0м зайд байрлана. Уг хүдрийн биет нь баруун хойш 3220 азимутаар, 260м урттай сунаж тогтсон, 1.0м дундаж зузаантай, 45.38%-ийн агуулгатай бэхэн ягаан өнгийн, дунд том мөхлөгт хайлуур жонш агуулдаг 1,0 м дундаж зузаантай байх ба хүдрийн биетийн уналын өнцөг 700, хайлуур жоншны дундаж агуулга 49.28% байна
- Жилд 300 хоног ажиллах ба 3 ээлжтэй, нэг ээлжийн үргэлжлэх хугацаа 8 цаг байна.
- Уурхай нь жилд 25 мян.тн хүдэр олборлох хүчин чадалтай.
- Тус уурхайд уурхайн удирдлага болон уурхайн ажилчдаас бүрдсэн нийт 75 хүн ажиллана.

### *Төслийн байршил*

“Уушиг уул-1” нэртэй хайлуур жоншны орд нь засаг захиргааны нэгжийн хувиараар Дундговь аймгийн Өлзийт, Сайнцагаан сумын нутагт хамаарах ба Мандалговийн төвөөс урагш 37 км, төмөр замын Чойр өртөөнөөс баруун урагш 200 км, Шивээ Овоогийн нүүрсний уурхайгаас баруун урагш 190 км, Хар айргийн хайлуур жоншны үйлдвэрээс баруун тийш

170 км зайтай байрладаг, Мандалговь болон бусад сумдтай шороон замаар холбогддог бөгөөд газар зүй-эдийн засгийн хувьд таатай бүс нутагт оршино.



Зураг 1. Төслийн байршлын зураг

## 1.2. Уурхайн ашиглалтын систем

Дундговь аймгийн Сайнцагаан, Өлзийт сумдын нутаг дэвсгэрт орших MV-021876 тоот ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй Уушиг уул-1 нэртэй хайлуур жоншны орд ил,далд хосолсон аргаар ашиглалт явуулах бөгөөд далд уурхай нь хүдэр хоршоолон нурах ашиглалтын системээр ашиглана.

### Ордын нөөц

“Уушиг уул-1” хайлуур жоншны ордын 1, 2-р хүдрийн биетэд бодитой болон боломжит нөөцийг геологийн хэсэгшлийн аргаар тооцоход ордын хэмжээнд бодитой (В) зэргээр 73.52 мян.тн хүдэрт 48.29%-ийн хайлуур жоншны агуулгатай 35.50 мян.тн хайлуур жонш, боломжтой (С) зэргээр 36.62 мян.тн хүдэрт 47.13%-ийн хайлуур жоншны агуулгатай 17.26 мян.тн хайлуур жонш, бодитой болон боломжитой (В+С) зэргээр 110.14 мян.тн хүдэрт 47.90%-ийн хайлуур жоншны агуулгатай 52.76 мян.тн хайлуур жонш гэж тооцсон байна.

Хүдрийн биет-1 Уг хүдрийн биет нь кварц-флюоритын судал хэлбэрээр өргөргийн дагуу 330м урттай, 1,0 м дундаж зузаантай байх ба хайлуур жоншны дундаж агуулга 49.28% байна. Хүдрийн биетийн хайлуур жонш нь жижиг- дунд, дунд, том талст үүсгэх ба ногооноос шаргал өнгөтэй байна.

Хүдрийн биет-2 нь мөн адил кварц-флюоритын судал бөгөөд хүдрийн биет-1-ээс баруун тийш 50.0-70.0м зайд байрлана. Уг хүдрийн биет нь баруун хойш 3220 азимутаар, 260м урттай сунаж тогтсон, 1.0м дундаж зузаантай, 45.38%-ийн агуулгатай бэхэн ягаан өнгийн, дунд том мөхлөгт хайлуур жонш агуулдаг.

### 1.3. Уурхайн хүчин чадал, ажиллах горим

Ил, далд уурхайн хүчин чадал нь жилд дунджаар 25.0 мян.тн хүдэр олборлох хүчин чадалтай бөгөөд тус онд 200 орчим хоног ажилласан бөгөөд 256 м далд уурхайн олборлолт нэвтрэлтийн ажлыг хийж гүйцэтгэсэн байна. Хавсралтаар 2024 оны малталт ахилтын хэмжээг маркшейдерийн хэмжилтээр баталгаажсан тайланг хүргүүллээ.

*Хүснэгт 1. Жилд ажиллах хоног*

| № | Үзүүлэлт                       | Хэмжээс          |
|---|--------------------------------|------------------|
| 1 | Хоног дахь ээлжийн тоо         | 3                |
| 2 | Ээлжийн үргэлжлэх хугацаа, цаг | 8                |
| 3 | Жилийн ажлын горим             | Улирлын чанартай |
| 4 | Хоногт ногдох ажлын нийт цаг   | 24               |
| 5 | Баяр ёслол, цаг агаарын саатал | 45               |
| 6 | Жилд ажилласан хоног           | 200              |


### 1.4. Далд уурхайн хэсэг

#### 1.4.1. Ашиглалтын технологи

Ашиглалтын систем нь ашигт малтмалыг хамгийн бага зардлаар бүрэн гүйцэд олборлох, өндөр бүтээмжтэй аюул осолгүй ажиллах нөхцөлийг хангасан байх ёстой.

Хүдрийн ордыг ашиглах олон төрлийн системийг хэрэглэх ба түүнийг сонгон авахад хүдрийн биетийн тогтоц, зузаан, уналын өнцөг, хүдэр болон хажуугийн чулуулгийн шинж чанар зэрэг голлон нөлөөлөх зүйлсийг харгалзан үзнэ. Ашиглалтын системийг сонгон авахад шийдвэрлэх гол зүйлийн нэг нь өрөмдлөг тэсэлгээ хийх, ачиж-тээвэрлэх зэрэг үйлдвэрлэлийн үндсэн процессуудыг механикжуулах асуудал юм. Уушиг уул-1 хайлуур жоншны ордод Хүдэр хоршоолох ашиглалтын системийг ашиглана. I болон II-р хүдрийн биет нь дунджаар 75° уналтай, нөөц тогтоосон гүн нь 50-100м, хүдрийн дундаж зузаан нь 0.95 м байна.

Хүдэр хоршоолох ашиглалтын систем: Хүдрийн биет болон хажуугийн чулуулаг нь хатуу, тогтвортой, судал нь нимгэн /0.95м/ учир олборлолтын орон зайг ил үлдээх ашиглалтын систем сонгосон. Олборлолтын орон зайд түр хадгалсан хүдэр дээрээс туушид нь /2 восстающий/ олборлон нураалт хийх хоршоолсон аргыг сонгон уурхайг ашиглахаар төлөвлөн ажиллаж байна



Зураг 2. Босоо амны хөндлөн зүсэлт

#### 1.4.2. Уурхайн нээлт

Ордын нээлтийн үндсэн параметрууд нь дараах 3-н хүчин зүйлээс хамаарна.

- Хүдрийн биетийн гадаад хүрээ ба суналын дагуу ашиглах хил хязгаар, хүдрийн биетийн оршин байгаа гүн ба далд уурхайн аргаар ашиглах гүнээр хязгаарлагдсан уурхайн талбай
- Уулын ажил гүйцэтгэх техник, тоног төхөөрөмжийн бэлэн байдал, техникийн боломжийг тооцсон хүчин зүйл болох далд уурхайн давхаргын өндөр, нээх үе шатлал
- Эдийн засгийн хүчин зүйл болох нээх алхмын хэмжээ, нээх алхам дахь давхаргын тоо зэргийг тооцдог.

#### 1.4.3. Уулын ажил

Тус ордыг ашиглах далд уурхайн хувьд хүдрийн биетүүдийн хэвтээ талд, нурлын бүсийн гадна талд эхний ээлжинд II-р судлыг нээх босоо амыг +1289.6 м-ээс +1185.51 м-ийн түвшин хүртэл нийт 104.66 м нэвтэрнэ.

Энэ ам нь хоёр судлын голд, I-р судлын босоо талд байрлаж байгаа тул бүрэн нэвтэрч дуусаад ашиглалтын үед геотехникийн судалгааг нарийвлан хийлгэж түүний дараагаас I-р судлыг нээх босоо амыг ашиглалтын 3 дахь жилээс эхлэн +1291.8 м-ээс +1185.51 м-ийн түвшин хүртэл нийт 106.29 м нэвтэрнэ. Дээрх босоо амнуудын тусламжтайгаар I судал дээр

ашиглалтын 2 түвшинд, II-р судал дээр ашиглалтын 1 түвшинд босоо амнаас босоо гол ам орчмын малталтыг нэвтэрсний дараагаар хүдрийн биетүүд рүү перпендукуляр чиглэлд квершлаг малталтуудыг хүдрийн биетүүд хүртэл нэвтэрч түүнээсээ суналын дагуу 2 тал руу огтолгооны штрек болон бусад малталтуудыг нэвтэрч хүдрийн биетийг нээнэ.

Хүснэгт 1.Календарчилсан төлөвлөгөө

| № | үзүүлэлтүүд     |      | Хэмжих нэгж | Ашиглалтын жил |         |         |         |         | Нийт    |
|---|-----------------|------|-------------|----------------|---------|---------|---------|---------|---------|
|   |                 |      |             | I жил          | II жил  | III жил | IV жил  | V жил   |         |
| 1 | Хүдэр олборлолт | Нийт | Тн          |                | 16994.4 | 22274.7 | 27542.6 | 21037.4 | 92892.2 |

|   |                           |      |    |         |         |         |          |         |          |
|---|---------------------------|------|----|---------|---------|---------|----------|---------|----------|
| 2 | Хүдрийн дундаж агуулга    | Нийт | %  | 45.17   | 43.93   | 43.93   | 43.93    | 43.93   | 43.93    |
| 3 | Хүдэр дэхь эрдсийн хэмжээ | Нийт | Тн | 9382.77 | 7333.1  | 9611.6  | 10967.6  | 9077.7  | 46372.80 |
| 4 | Уулын цулын хэмжээ        | Нийт | Тн |         | 39059.2 | 33071.9 | 288811.8 | 23875.1 | 124818.8 |


#### 1.4.4. Далд уурхайн тоног төхөөрөмж

Хүснэгт 2. Далд уурхайн тоног төхөөрөмж

| №  | Тоног төхөөрөмжийн нэр   | Марк      | Тоо хэмжээ |
|----|--------------------------|-----------|------------|
| 1  | Гар өрөм                 | ҮТ-28     | 6          |
| 2  | Өргөх хөнөг              | БП-0.8    | 2          |
| 3  | Тэргэнцэр                | KFU-0.8   | 8          |
| 4  | Өргөх төхөөрөмж          | JT-18     | 2          |
| 5  | Төмөр зам                | РТ-18     | 8м         |
| 6  | Лёбёдка                  | 17ЛС-2СМ  | 2          |
| 7  | Скрепер                  | СГ-0,25   | 1          |
| 8  | Компрессор               | FC-20     | 2          |
| 10 | Бетон шүршиг             | FZ-50     | 3          |
| 11 | Вентилятор               | ВМЭ-8     | 1          |
| 12 | Вентилятор               | БОЭ-5     | 1          |
| 13 | Шахуурга                 | ЦНС13-105 | 1          |
| 14 | Бадьяа                   | БПСМ-3    | 2          |
| 15 | Дизель генератор         | САТ-3608  | 1          |
| 16 | Гэрэлтүүлэг              | РН-100    | 100        |
| 17 | Төмөр зам                |           | 150        |
| 18 | Засварын тоног төхөөрөмж | R-75      | 1          |

#### 1.5. Баяжуулах технологи

Тус ордын жоншны хүдрийг гар аргаар ялгаж, ФК-75 маркийн бүхэллэг жонш гарган авах технологийг боловсрууллаа. Анхдагч хүдрийг уурхайн талбайд ангилан баяжуулж, хоосон чулуулаг ялгаж, тээвэрлэх хүдрийн хэмжээг бууруулах замаар төслийн эдийн засгийн үр өгөөжийг нэмэгдүүлэх бодит боломжийг бүрдүүлэх юм. Уурхайгаас ирсэн хүдрийн овоолгоос ангилан ялгах цехэд дугуйт ачигчаар хяналтын 300 мм нүхтэй гулдмай шигшүүртэй бункерийг ачаална. Хүдэр бункерээс анхан шатны бутлуур руу өгөгдөх бөгөөд бутлагдсан хүдэр ялтсан тэжээгүүрийн тусламжтайгаар чичиргээт шигшүүрт өгөгдөн 40 мм ширхэглэлээр ангилагдана. Шигшүүрээс +40 мм ангилал тус бүрээр ялгалтын туузан дамжуулгаар тээвэрлэгдэн 85% нь гар ялгалтад орж үлдэгдэл -40 мм-ийн бүтээгдэхүүн нь шууд баяжуулах үйлдвэр рүү тээвэрлэгдэнэ. Жоншны хүдрээс гар аргаар ялган авсан таваарын баяжмалын агуулга 75% байхаар бодож бүтээгдэхүүний балансыг тооцсон болно.



Зураг 3.Гар аргаар ангилах цехийн технологийн схем


Уурхайгаас нийлүүлэгдэх хүдрийг (<300мм) хацарт бутлуураар 75 мм хүртэл бутлан, бутлагдсан хүдрийг чичиргээт шигшүүрээр шигшин шигшүүрийн доод бүтээгдэхүүнийг буюу -40 мм ангиллын фракцыг үлдэгдэл хүдрийн овоолгод зөөвөрлөн хураана. Шигшүүрийн дээд +40 ангиллын бүтээгдэхүүнийг гар ялгалт хийн ФК-75 маркийн бүхэллэг жонш гарган авах ба бага агуулгатай хүдрийг мөн овоолгод хураана.

#### Хүдэр ангилах цех

Ангилан ялгах цехийн хүчин чадлыг төсөл захиалагчаас ирүүлсэн техникийн даалгаварт санал болгосны дагуу болон уулын ажлын хүчин чадалтай уялдуулж жилд 20.0 мян.тн орчим хүдэр ангилан ялгах аргаар төлөвлөсөн байна. “Идэр Макс” ХХК-ийн “Уушиг уул-1” хайлуур жоншны ангилан ялгах цех нь улирлын чанартай ажиллах бөгөөд хавар 4 дүгээр сарын эхнээс намар 10 дугаар сарын сүүл хүртэл жилд дунджаар 187 хоног орчим ажиллана. Ангилан ялгах цех нь хоногт 9 цагийн 1 ээлжээр ажиллана.

Хүснэгт 3. Хүдрийг гар аргаар ангилан ялгах технологийн бүтээгдэхүүний баланс

| Бүтээгдэхүүний нэр             | Q тн/цаг | Агуулга | Гарц   | Жонш авалт |
|--------------------------------|----------|---------|--------|------------|
| ФК-75 маркийн бүхэллэг жонш    | 5.94     | 75.00   | 39.59  | 67.21      |
| Бага агуулгатай хүдэр          | 6.81     | 17.30   | 45.41  | 17.79      |
| 40 мм -ээс доош ангиллын хүдэр | 2.25     | 44.18   | 15.00  | 15.00      |
| Анхлагч хүдэр                  | 15.00    | 44.18   | 100.00 | 100.00     |



Зураг 4. Хүдэх ангилах хэсгийн технологийн схем

Хайлуур жоншны хүдрийг гар ялгалтын аргаар боловсруулж ФК-75 маркийн металлургийн бүхэллэг жонш болон 24.88 хувь СаF2-ын агуулга бүхий хүдрийг гарган авах технологийг сонгов. Металлургийн бүхэллэг жоншийг шууд БНХАУ-руу экспортод гаргах ба 44.18 хувь СаF2-ын бага агуулга бүхий +40 мм ширхэглэлтэй болон 17.30 хувь СаF2-ын бага агуулга бүхий -40 мм ширхэглэлтэй буюу дунджаар 23.98 хувь СаF2-ын агуулгатай хүдрийг баяжуулах үйлдвэрт борлуулна. Төслийн талбайгаас ойролцоогоор 100 гаруй км зайд Дундговь аймгийн Баянжаргалан сумын нутагт орших “Болор жонш” ХХК-ий жоншны баяжуулах үйлдвэр байдаг. Тус үйлдвэр нь ойролцоох ордуудаасаа бага агуулгатай хүдр худалдаж аван баяжуулдаг үйлдвэр юм. Мөн төслийн талбайгаас урагш Дорноговь аймагт Өндөршил болон Айраг сумуудад жоншны баяжуулах үйлдвэрүүд байдаг. Иймээс бага агуулгатай хүдрээ тухайн баяжуулах үйлдвэрүүдэд борлуулах боломжтой.

Хүснэгт 4. Бүтээгдэхүүн гаргалтын тооцоо /жил бүрээр/

| №                           | үзүүлэлтүүд                  | Хэмжих нэгж | Ашиглалтын жил |          |          |          |           | Нийт      |
|-----------------------------|------------------------------|-------------|----------------|----------|----------|----------|-----------|-----------|
|                             |                              |             | I жил          | II жил   | III жил  | IV жил   | V жил     |           |
| Анхдагч хүдэр               |                              |             |                |          |          |          |           |           |
| 1                           | Ангилах цехийн ажиллах хоног | Хоног       | 185            | 151      | 194      | 219      | 184       | 934       |
| 2                           | Гар аргаар ангилах хүдэр     | Тн          | 20.772.0.      | 16.692.4 | 21.878.9 | 24.965.5 | 20.663.6. | 104.972.5 |
| 3                           | Дундаж агуулга               | %           | 45.17          | 43.93    | 43.93    | 43.93    | 43.93     | 44.18     |
| 4                           | Эрдэс нөөц                   | Тн          | 9.382.8        | 7.333.1  | 9.611.6  | 10.967.6 | 9.077.7   | 46.373    |
| ФК-75 маркийн бүхэллэг жонш |                              |             |                |          |          |          |           |           |
| 5                           | Агуулга                      | %           | 75.00          | 75.00    | 75.00    | 75.00    | 75.00     | 75.00     |
| 6                           | Жонш авалт                   | %           | 67.21          | 67.21    | 67.21    | 67.21    | 67.21     | 67.21     |
| 7                           | Баяжмал дах эрдэс            | Тн          | 6306.5         | 4928.9   | 6460.3   | 7371.5   | 6101.5    | 31169.3   |

|                          |                   |    |        |        |        |         |        |         |
|--------------------------|-------------------|----|--------|--------|--------|---------|--------|---------|
| 8                        | Гарц              | %  | 40.5   | 39.4   | 39.4   | 39.4    | 39.4   | 39.59   |
| 9                        | Хэмжээ            | Тн | 8408.7 | 6571.9 | 6571.9 | 9829.0  | 8135.3 | 41558.6 |
| Баяжуулах хүдэр          |                   |    |        |        |        |         |        |         |
| 10                       | Агуулга           | %  | 17.30  | 17.30  | 17.30  | 17.30   | 17.30  | 17.30   |
| 11                       | Жонш авалт        | %  | 17.79  | 17.79  | 17.79  | 17.79   | 17.79  | 17.79   |
| 12                       | Баяжмал дах эрдэс | Тн | 1668.8 | 1304.3 | 1709.5 | 1950.7  | 1614.6 | 8247.9  |
| 13                       | Гарц              | %  | 46.4   | 45.2   | 45.2   | 45.2    | 45.2   | 45.2    |
| 14                       | Хэмжээ            | Тн | 9644.8 | 7538.0 | 9880.1 | 11273.9 | 9331.3 | 47668.0 |
| -40мм ширхэглэлтэй хүдэр |                   |    |        |        |        |         |        |         |
|                          | Агуулга           | %  | 44.18  | 44.18  | 44.18  | 44.18   | 44.18  | 44.18   |
|                          | Жонш авалт        | %  | 15.00  | 15.00  | 15.00  | 15.00   | 15.00  | 15.6900 |
|                          | Баяжмал дах эрдэс | Тн | 1407.4 | 1100.0 | 1441.7 | 1645.1  | 1361.7 | 6955.9  |
|                          | Гарц              | %  | 13.09  | 15.47  | 15.47  | 15.47   | 15.47  | 15.00   |
|                          | Хэмжээ            | Тн | 2718.5 | 2582.6 | 3385.1 | 3862.6  | 3197.1 | 15745.9 |

#### Бага агуулгатай болон – 25мм ширхэглэлтэй хүдэр

“Уушиг уул-1” нэртэй жоншны ордын ашиглалтын 5 жилийн хугацаанд дунджаар 23.98 хувь CaF<sub>2</sub>-ын агуулгатай 63413.9 тн хүдрийг баяжуулах үйлдвэрт борлуулна.

5 жилийн хугацаанд баяжуулах үйлдвэрт нийлүүлэх -40мм-ээс бага ширхэглэлийн болон бага агуулгатай хүдрийн хэмжээг дараах хүснэгтээр үзүүлээ

Хүснэгт 5. Баяжуулах цехийн нийт бага агуулгатай болон -40 мм ширхэглэлтэй хүдэр гаргалт

| № | Үзүүлэлтүүд        | Хэмжих нэгж | Ашиглалтын жил |         |         |         |         | Нийт    |
|---|--------------------|-------------|----------------|---------|---------|---------|---------|---------|
|   |                    |             | I жил          | II жил  | III жил | IV жил  | V жил   |         |
| 1 | Агуулга            | %           | 24.88          | 23.76   | 23.76   | 23.76   | 23.76   | 23.98   |
| 2 | Жонш авалт         | %           | 32.79          | 32.79   | 32.79   | 32.79   | 32.79   | 32.79   |
| 3 | Баяжмал дахь эрдэс | тн          | 3076.2         | 2404.3  | 3151.3  | 3595.8  | 2976.2  | 15203.8 |
| 4 | Гарц               | %           | 59.5           | 60.6    | 60.6    | 60.6    | 60.6    | 60.4    |
| 5 | Хэмжээ             | Тн          | 12363.3        | 10120.6 | 13265.2 | 15136.5 | 12528.3 | 63413.9 |

#### 1.5.1. Баяжуулах цехийн тоног төхөөрөмж

Хүснэгт 6. Баяжуулах цехийн тоног төхөөрөмж

| №                          | Тоног төхөөрөмжийн жагсаалт | Стандарт загвар | Нэгж | Тоо хэмжээ | Хүчин чадал | Тайлбар                                |
|----------------------------|-----------------------------|-----------------|------|------------|-------------|----------------------------------------|
| Бутлах болон шигших систем |                             |                 |      |            |             |                                        |
| 2                          | Тэжээгч                     | CG980x1240      | ш    | 1          | 7.5         | Трансформатор                          |
| 3                          | Хацарт бутлуур              | PE400*600       | ш    | 1          | 15          | Цахилгаан удирдлагатай                 |
| 4                          | Ялтаст тэжээгүүр            | BW80-L          | ш    | 1          | 15.         | Цахилгаан удирдлагатай                 |
| 5                          | Чичиргээт шигшүүр           | YK1224          | ш    | 1          | 5.5         | Шигшүүрийн нүх                         |
| 6                          | Туузан конвейер             | DT2A            | ш    | 1          | >20         | Гадна байрлуулах моторын онхрөлт L=40m |

|   |                   |       |   |   |     |                           |                       |
|---|-------------------|-------|---|---|-----|---------------------------|-----------------------|
| 7 | Туузан дамжуулагч | B=500 | ш | 1 | 2.5 | Гадна<br>моторын<br>L=35m | байрлуулах<br>өнхрөлт |
|---|-------------------|-------|---|---|-----|---------------------------|-----------------------|

#### 1.6. Дэд бүтэц

**Гадаад цахилгаан хангамж:** Уурхайн цахилгаан хэрэглэгчдийг төвлөрсөн цахилгаан хангамжаас эрчим хүчээр хангах боломжгүй учир дизель цахилгаан үүсгүүрээс цахилгаан эрчим хүчээр хангахаар төсөлд тусгаж байна. Далд уурхай болон хотхоны дэргэд 200кВА-ын 1 ширхэг дизель станц байрлуулж цахилгаан эрчим хүчээр хангана. Нөөцөд мөн ижил төрлийн 1 ширхэг дизель цахилгаан үүсгүүр ажиллана.

**Дотоод цахилгаан хангамж:** Тус хайлуур жоншны ордыг ашиглах далд уурхайн цахилгаан хэрэглэгчид нь:

1. Далд уурхай (босоо гол амны өргөх машин ерөнхий агааржуулалтын суурин сэнс, компрессор)

2. Баяжуулах үйлдвэр

3. Ус татах насос

4. Далд уурхай болон үйлдвэрийн талбайн гэрэлтүүлэг

5. Тэсрэх материалын агуулах

6. Шатахуун түгээх станц

7. Засварын цех

8. Захиргаа аж ахуй, кемп гэх мэт юм.

**Уурхайн тосгон:** Уг уурхайн талбайд тосгоны барилга байгууламжийн ажлыг 2020 оны 05-р сараас эхлэн хийж гүйцэтгэсэн. Ажиллагсадын тосгон болон уурхайн захиргаа зэргийг уурхайгаас баруун хойд зүгт 1км зайд барьж байрлана. Мөн үйлдвэрийн захиргааны үйлчилгээний байруудыг үйлдвэрийн объектуудын дэргэд барина. Энд захиргааны ажилтнуудын контороос гадна хоолны газар, халуун ус, эмнэлэгийн цэгийг байрлана.



Зураг 5. Уурхайн тосгоны барилга байгууламж

**Усан хангамж:** Гидрогеологийн судалгаагаар газрын доорх усны ундаргыг 0.3-1.6 л/сек гэж тогтоожээ. Төслийн унд ахуйн хэрэглээний усыг гүний усаар хангах боломжтой гэж үзсэн ба зэргэлдээ 3-5 км-т орших 2 худгийн ундарга 1.5-1.92 л/сек байгаа нь судалгаагаар тогтоогдсон байна.

**Дулаан хангамж:** Уурхайн тосгон, захиргаа аж ахуйн байр зэрэг байгууламжуудыг дулаанаар хангана. Дулааны хангамжийг уурхайн дэргэд байгуулагдах нам даралтын зуухаар хангана. Барилга байгууламжийн угсралтын ажил гүйцэтгэхдээ дотоод дулаан хангамжийг холбогдох нормын дагуу хамт гүйцэтгэнэ. Гадна дулаан хангамжийн барилга угсралтын ажлыг дулаан үүсгэгчээс шугам татах замаар холбогдох барилгын нормын дагуу гүйцэтгэнэ.

## 2. ТӨСӨЛ ХЭРЭГЖИЖ БУЙ ГАЗРЫН ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

### 2.1. Байгаль орчин, нийгэм-эдийн засгийн төлөв байдлын товч танилцуулга

#### *Төслийн байршлын физик газарзүйн нөхцөл*

Хэнтийн уулсын системээс Говийн бүсэд шилжих хэсэгт байрших ба талбайн ихэнхи хэсэг нь далайн түвшнээс дээш 1100-1200 м харьцангуй өндөртэй жижиг толгодорхог гадаргуу үүсгэнэ. Талбайн хамгийн өндөр цэг Уушиг уул-1 нь далайн түвшнээс дээш 1290м өргөгдсөн. Гадаргуугийн хэлбэр зөөлөн толигор, хөндийн ёроолоос хажуугийн мөрөгцөг дэх харьцангуй өндөржилт 100 м хүрнэ

**Усан сүлжээ:** Районы хэмжээнд тогтмол урсгалтай усан сүлжээ хөгжөөгүй. Судалгааны талбай харьцангуй цөөн худагтай. Гадаргуугийн ус ховор бөгөөд хур тунадаснаас хамааралтай. Гар худгуудын ундарга 200-4000 л/ц байдаг. Районы хэмжээнд гадаргуугийн доош суусан хэсгүүдэд нилээд тооны тойром тэмдэглэгдэнэ. Ихэнхи тойрмууд нь байнгын тэжээгдлийн эхгүй, борооны усаар дүүргэгдсэн жижиг сав газруудтай холбоотой үүссэн. Нууруудын гүн 1.5-2.0 м-ээс илүүгүй

**Цаг агаар, уур амьсгал:** Район нь жилийн, сарын, хоногийн температурын эрс, мэдэгдэм хэлбэлзэлтэй ба бага хэмжээний хур тунадас унадаг, хуурай, тогтворгүй, эх газрын эрс тэс уур амьсгалтай. Цас багатай, хүйтэн өвөл 4-5 сар үргэлжлэнэ. Хамгийн хүйтэн сарууд 12,1-р сарууд ба сарын дундаж температур -200 –оос -320С –д хэлбэлзэнэ. Хөрсний улирлын хөлдөлтийн гүн 3.0 м-ээс хэтрэхгүй, гэхдээ тал хөндий газруудаар хөрсний гэсэлт удаан явагдах ба энгэр ээвэр хэсгүүдээр 5-р сард дууссан байдаг. Хавартаа хуурай, голчилон баруун ба баруун хойноосоо салхилж, ялангуяа 4, 5, 6 сард салхины хүч ихсэж дунджаар 14-16 м/с, зарим үед 20-25 м/с хүрнэ. Зун нь богинохон, халуун, хуурай салхитай. Намартаа хуурай, сэрүүвтэр. Хээрийн судалгаа явуулахад тохиромжтой хугацаа 5-аас 10-р сарууд болно. Жилийн дундаж хур тунадасын хэмжээ 100 -150 мм, ихэнх хур тунадас нь 6-р сард ордог онцлогтой

**Хөрсөн бүрхэвч:** Төслийн талбайн район нь Монгол орны хөрс-газарзүйн мужлалаар Хангайн их мужийн Хэнтийн муж, Хэнтийн төвийн тойрогт хамаарагдана (ШУА, Газарзүйн хүрээлэн, 2009). Хээрийн судалгаа болон лабораторийн шинжилгээний үр дүнг үндэслэн төслийн талбайд бүхэлдээ ердийн хар хүрэн, сайр чулуурхаг хар хүрэн хөрс тархсан байна.

**Ургамлан нөмрөг:** Ургамал газарзүйн мужлалаар Төв Азийн говийн их мужид, газар зүйн хэлбэр, гадаргуугийн хэв шинжээр ухаа гүвээт тэгш талын өндөрлөг хэв шинжид багтана.Төслийн талбай нь ургамал газарзүйн мужлалаар Монголын хээрийн мужийн Дорноговийн цөлөрхөг хээрийн тойрогт хамаарагдана. (Юнатов 1984. Өлзийхутаг 1989)

Талбайн хэмжээнд хамгийн өндөр өргөгдсөн цэг нь талбайн урд, зүүн урд захаар орших далайн түвшнээс дээш 1150м-т, хамгийн намхан цэг нь 950 м-ийн өндөртэй байх бөгөөд харьцангуй өндөршилт 50-150м орчим байна. Толгодууд, гүвээ нь мөлгөр оройтой, аажим налуу хажуутай, уужим тавиу өргөн хөндий хөгжсөн байдаг.

Хойд говийн цөлөрхөг хээрийн мужийн монгол өвс- хазаар өвст хээрийн бүсэд багтана. Ус чийг багатай, салхитай учир ургамлын бүрхүүл сийрэгдүү байдаг. Толгодын бударгана, сайрын хялгана, говийн хялгана зэрэг бутлаг ургамал, агь , монгол өвс, хазаар өвс, шарилж, ерхөг зэрэг нэг наст болон олон наст ургамал ургадаг. Ургамал ерөнхийдөө сийрэг боловч тачирхан, тэжээллэг чанар сайтай учир бэлчээрийн багагүй ач холбогдолтой

**Амьтны аймаг:** Эрс тэс уур амьсгалтай Монгол оронд өөр хоорондоо ялгаатай олон янзын экосистемд дасан зохицсон 128 зүйл хөхтөн амьтан, 476 зүйл шувуу, 16 зүйл мөлхөгч, 6 зүйл хоёр нутагтан, 74 зүйл загас, 13 мянга орчим зүйлийн шавж бүртгэгдээд байна. Амьтны тухай хуулиар 28 зүйл амьтан “нэн ховор”, Засгийн газрын 2012 оны 07 дугаар тогтоолоор 76 зүйл амьтан “ховор” амьтны жагсаалтад бүртгэгдээд байна. Амьтны амьдрах орчинд учруулж байгаа дарамт, ашиглалтын улмаас хөхтөн амьтдын зүйлийн 16% нь бүс нутгийн хэмжээнд устах аюултай, 2% нь устаж байгаа, 11% нь устаж болзошгүй, 3% нь эмзэг буюу байгальд устах эрсдэл өндөр, шувуудын зүйлийн 4% нь тоо толгой буурсан, нэн ховор, ховор ургамлын зүйлийн 11% нь устаж байгаа, 26% нь устаж болзошгүй, 37% нь эмзэг буюу байгальд устах эрсдэл өндөр, 15% нь ховордож болзошгүй байна. Тус төслийн байршлын хувьд төв азийн тал хээрийн бүсийн хэв шинжтэй. Хамгийн элбэгээр зээр, үнэг, хярс, чоно, мануул, дорго амьдрах ба зундаа хун, галуу, нугас, тогоруу ирж нутаглах нь бий. Мөн олон тооны мэрэгчүүд, могой, гүрвэл элбэг

**Хүн ам, эдийн засаг, зам харилцаа:** Хүн ам сийрэг, нүүдлийн мал аж ахуй эрхэлдэг халхчууд суурьшин амьдардаг. Хүн амын нягтаршил 1 ам.км талбайд 0.26 хүн оногдоно. Өлзийт, Сайнцагаан сумын төвд сургууль, цэцэрлэг, холбоо, дэлгүүр, эмнэлэгтэй, төвлөрсөн эрчим хүчний системд холбогдсон. Уг сум нь Улаанбаатар хотоос 307 км, төмөр замын Чойр өртөөнөөс 200 км, Хар айраг өртөөнөөс 190 км-д орших ба Мандалговь болон бусад сумдуудтай шороон замаар холбогдоно.

### 3. ТӨСЛИЙН ГОЛ БОЛОН БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ

#### 3.1. Төслийн гол болон болзошгүй сөрөг нөлөөллийн товч тодорхойлолт

Дундговь аймгийн Сайнцагаа, Өлзийт сумдын нутаг дэвсгэрт орших Уушиг-уул нэртэй хайлуур жоншны ордыг ил далд хосолсон аргаар ашиглах төслийн явцад байгаль орчинд үзүүлэх нөлөөллийг тодорхойлж, тэдгээрийг бууруулах, арилгах ажлын төлөвлөгөөг боловсруулах зорилгоор НҮБ-ын Ази Номхон далайн орнуудын нийгэм эдийн засгийн комиссын болон Азийн хөгжлийн банк, Дэлхийн банкнаас гаргасан байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний заавар, гарын авлагыг ашиглан магадлан жагсаах аргаар голлох нөлөөллүүдийг тогтоож үнэлгээг гарган хүснэгтэд харуулав.

Хүснэгт 7. Төслийн байгаль орчин, хүний эрүүл мэндэд үзүүлэх гол болон болзошгүй сөрөг нөлөөлөл

| Нөлөөлөгч                                                                                   | Хэлбэр |          | Хугацаа          |               | Чиглэл          |           |       | Эрчим  |            |            |
|---------------------------------------------------------------------------------------------|--------|----------|------------------|---------------|-----------------|-----------|-------|--------|------------|------------|
|                                                                                             | Шууд   | Шууд бүс | Богино хугацааны | Урт хугацааны | Буцааж нөлөөлөх | Буцалтгүй | Өөрөө | Хүчтэй | Дунд зэрэг | Бага зэрэг |
| Нөлөөлөлд өртөгч                                                                            |        |          |                  |               |                 |           |       |        |            |            |
| 1. Байгаль, экосистемийн өөрчлөлт                                                           |        |          |                  |               |                 |           |       |        |            |            |
| Агаарын чанар                                                                               | X      |          | X                |               |                 |           | X     |        | X          |            |
| Хөрсөн бүрхэвчийн эвдрэл, бохирдол                                                          | X      |          |                  | X             |                 | X         |       | X      |            |            |
| Чимээ шуугиан (физик нөлөөлөл)                                                              |        | X        | X                |               |                 |           | X     |        |            | X          |
| Хүн амд мэдэрхүйн тааламжгүй нөлөөлөл                                                       | X      |          | X                |               |                 |           | X     |        |            | X          |
| Гадаргын усны чанарын өөрчлөлт                                                              | X      |          |                  | X             |                 |           |       | X      |            |            |
| Газрын доорх усны чанарын өөрчлөлт                                                          | X      |          |                  | X             |                 |           |       | X      |            |            |
| Ургамлын бүтцийн өөрчлөлт                                                                   | X      |          |                  | X             |                 | X         |       |        | X          |            |
| Геологийн тогтоцын өөрчлөлт                                                                 |        | X        |                  | X             |                 |           |       |        |            | X          |
| Зэрлэг амьтдын орон зай                                                                     |        | X        | X                |               |                 |           | X     |        |            | X          |
| 2. Байгалийн нөөц ашиглалт                                                                  |        |          |                  |               |                 |           |       |        |            |            |
| Газрын гадаргын нөөц ашиглалт                                                               | X      |          | X                |               |                 |           | X     |        |            | X          |
| Бэлчээрийн байдал                                                                           |        | X        | X                |               |                 |           | X     |        |            | X          |
| Гадаргын усны урсацын өөрчлөлт, ашиглалт                                                    | X      |          |                  | X             |                 |           |       | X      |            |            |
| Газрын доорх усны нөөц, горим                                                               | X      |          |                  | X             |                 |           |       | X      |            |            |
| 3. Байгалийн өнгө төрх, түүх соёлын дурсгалт зүйл, археологи, палентлогийн олдвор           |        |          |                  |               |                 |           |       |        |            |            |
| Байгалийн үзэсгэлэнт өнгө төрх өөрчлөгдөх                                                   | X      |          |                  | X             |                 | X         |       | X      |            |            |
| Ландшафтын хэлбэр өнгө төрх өөрчлөгдөх                                                      | X      |          | X                |               | X               |           |       |        | X          |            |
| Тусгай хамгаалалттай газар нутаг өөрчлөгдөх                                                 |        | X        |                  |               |                 |           |       |        |            |            |
| Түүх соёлын дурсгалт зүйлд нөлөөлөх                                                         |        | X        |                  |               |                 |           |       |        |            | X          |
| Археологи, палентлогийн олдворт нөлөөлөх                                                    |        | X        |                  |               |                 |           |       |        |            | X          |
| 4. Эдийн засаг, нийгмийн нөлөө                                                              |        |          |                  |               |                 |           |       |        |            |            |
| Орон нутаг, иргэдийн орлого нэмэгдэхэд                                                      | X      |          |                  |               |                 |           |       |        | X          |            |
| Ажлын байр нэмэгдэхэд                                                                       | X      |          |                  |               | X               |           |       |        | X          |            |
| Ядуурлыг бууруулах дэмжлэг болох                                                            | X      |          |                  |               |                 |           |       |        |            | X          |
| 5. Бусад нөлөөлөл                                                                           |        |          |                  |               |                 |           |       |        |            |            |
| Уурхайн талбайн ойролцоох ой мод, бусад сөөг ургамлууд уурхайн үйл ажиллагаанд өртөх, устах | X      |          |                  | X             |                 | X         |       | X      |            |            |
| Эвдэгдсэн газрыг нөхөн сэргээх                                                              | X      |          |                  | X             |                 |           | X     | X      |            |            |
| Галын аюулгүй байдал алдагдах                                                               | X      |          |                  |               | X               |           |       |        |            | X          |

|      |    |   |   |    |   |   |   |   |   |    |
|------|----|---|---|----|---|---|---|---|---|----|
| Нийт | 18 | 7 | 7 | 10 | 3 | 4 | 7 | 8 | 5 | 10 |
|------|----|---|---|----|---|---|---|---|---|----|

**Шууд нөлөөлөл:** Тус Уушиг уул -I хайлуур жоншны ордыг ил далд аргаар ашиглах төслийн үйл ажиллагаанаас шууд үзүүлэх нөлөөлөл нь агаарын чанар, хөрсөн бүрхэвчийн эвдрэл, ургамлын бүтцийн өөрчлөлт, гадаргын болон газрын доорх усны чанар, нөөцийн өөрчлөлт, ландшафтын хэлбэр өнгө төрх өөрчлөгдөх гэх мэт экосистемийн сөрөг өөрчлөлт гарахаар байна. Харин эерэг нөлөөллийн хувьд орон нутгийн иргэдийн орлого, ажлын байр, нэмэгдэх зэрэг ядуурлыг бууруулахад дэмжлэг болох эерэг шууд нөлөөллийг үзүүлэхээр байна. Мөн хууль бус аль олборлогчдын нөлөөгөөр эвдэгдсэн байгаа газрыг нөхөн сэргээх эерэг нөлөөлөл харагдаж байна.

**Шууд бус нөлөөлөл:** Төслийн дам нөлөөлөл нь зэрлэг амьтдын орон зай, түүх соёл, геологийн тогтоц өөрчлөгдөх мөн шатах тослох материал (уурхайн үйл ажиллагаа болон тээврийн хэрэгслээс үүдэх) асгаран хөрсийг бохирдуулснаар хөрсний усыг бохирдуулан, саармагжуулаагүйн улмаас гүний усанд нөлөөлөл үзүүлж болзошгүй юм.

**Богино хугацааны нөлөөлөл:** Төслийн хэрэгжих хугацаанд ургамлан нөмрөг, талхагдал, агаарын чанар зэрэг үзүүлэх нөлөөлөл байгаа боловч эдгээр нь урт хугацааг хамрахгүй, зөвхөн тухайн үед үзүүлэх нөлөөлөл байна. Тухайлбал газар шорооны ажил, уурхайн ачилт буулгалт, барилгын хүнд техникийн ажлын үед бий болох дуу чимээ ба тоосжилт үүсэх, хог хаягдлыг түр хадгалах, хүний хөл хөдөлгөөний явцад байгаль орчны бүрэлдэхүүн хэсгүүдэд үзүүлэх нөлөөлөл нь богино хугацаанд үргэлжлээд дуусна.

**Урт хугацааны нөлөөлөл:** Уурхайн үйл ажиллагаанаас үүсэх экосистемийн өөрчлөлт буцан сэргэх, сөрөг нөлөөлөл арилах хүртэл тодорхой хэмжээний хугацаа зарцуулах учир урт хугацааны нөлөөлөлд багтаж байна.

**Буцаж нөлөөлөх:** Төслийн үйл ажиллагаанаас байгаль орчинд буцаж нөлөөлөх нөлөөлөл нь бага байна. Төслийн явцад тээврийн хэрэгслийн хөдөлгөөний нөлөөгөөр хөрсөн бүрхэвч механик эвдрэлд орох, ургамлан нөмрөг талхлагдах, төслийн талбай орчмын бут сөөг устахаар байгаа боловч нөлөөлөлд өртсөн хэсгийг тухай бүрд нь нөхөн сэргээх, дүйцүүлэн хамгаалах арга хэмжээг авч үйл ажиллагааны туршид хариуцлагатай, зохион байгуулалттай ажиллавал хөрс, ургамлан нөмрөг нөхөн сэргэх, хэвийн төлөв байдалдаа шилжих боломжтой бөгөөд эдгээрийг анхаарах хэрэгтэй юм.

**Өөрөө зохицуулагдах:** Төслийн үйл ажиллагаанаас агаарын чанарт үзүүлэх нөлөөлөл нь тархах хүрээ хомс, нөлөөллийн хэмжээ бага, эрчим нь сул, салхиар зөөгдөн замхрах шинж чанартай тул өөрөө зохицуулагдах гэж авч үзлээ.

**Бага зэргийн нөлөөлөл:** Энэхүү төслийн үйл ажиллагааны явцад тээврийн хэрэгслүүд тодорхой маршрутын дагуу зорчсоноор хөрсөн бүрхэвч механик элэгдэлд өртөх, агаарын чанар сөргөөр нөлөөлөх гэх нөлөөллүүд байгаль орчинд бага зэргийн нөлөөллийг үзүүлнэ. **Нөлөөллийн эрч хүч:** Дээрх хүснэгтээс үзэхэд бараг бүх нөлөөлөл нь бага эрчтэй болохоор байна. Гэвч хөдөлмөр аюулгүй байдал алдагдах, гэнэтийн осол буюу үйл ажиллагааны явцад эрч хүч нь нэмэгдэх магадлалтай байхыг байнга санаж үйл ажиллагаа

явуулах хэрэгтэй.

#### 4. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫГ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ, ҮНДСЭН ҮР ДҮН

Дундговь аймгийн Сайнцагаан суманд орших хайлуур жоншны ил уурхайн Байгаль орчны менежмент төлөвлөгөөний биелэлтийн тайланг боловсруулахдаа БОАЖЯ-ны сайдын 2019 оны 10 сарын 29-ны өдрийн А-618 тушаалаар батлагдсан “Байгаль орчны менежмент төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам”-ыг баримтлав. Түүний дагуу тухайн жилийн төлөвлөгөөнд тусгагдсан ажлуудын биелэлтийг нэг бүрчлэн тодорхойлж, хөрөнгө зардлыг тооцсон бөгөөд орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн биелэлтийн хэсэгт хяналт шинжилгээний ажлын үр дүнг дэлгэрэнгүй хэлбэрээр тусгасан болно.

2024 оны Байгаль орчны менежмент төлөвлөгөөний хүрээнд хэрэгжүүлсэн гол үйл ажиллагаанууд, түүний үр дүнг дурдвал:

- “Тэрбум мод” үндэсний хөтөлбөрийг дэмжих, мөн уурхайн үйл ажиллагаанаас үүсэж болзошгүй ургамлан нөмрөгийн талхлалт болон тоосжилтыг бууруулах зорилгоор уурхайн хотхоны дотор хайлаас, шар хуас гэсэн 2 төрлийн нийт 85 ширхэг мод тарьсан. Сайнцагаан сумтай хамтран ажиллаж аймгийн төвд ногоон байгууламж тарих, хашаажуулах, 100 жилийн ой гэх мэт ажлуудад хөрөнгө оруулалт хийж нийгмийн хариуцлагын хүрээнд 100 сая төгрөгийн дэмжлэг үзүүлсэн. Мөн Сайнцагаан сумын 1 оюутны төлбөрийг төлсөн.
- Уурхайн үйл ажиллагаанаас үүдэлтэй гол ба болзошгүй сөрөг нөлөөллийг хянах, бууруулах зорилгоор агаарын чанар, газрын доорх ус, хөрсөн бүрхэвч зэрэг 3 чиглэлээр орчны хяналт шинжилгээний ажлуудыг хийж гүйцэтгэсэн.

Байгаль орчны менежмент төлөвлөгөөнд тусгагдсан ажлууд түүний биелэлтийн тоон үзүүлэлтийг дараах хүснэгтэд нэгтгэн илэрхийлэв.

*Хүснэгт 5. Байгаль орчны менежмент төлөвлөгөөнд тусгагдсан ажлуудын хэрэгжилт*

| Д/д | Байгаль орчны хамгаалах арга хэмжээний төрөл               | Төлөвлөсөн ажлын тоо | Гүйцэтгэсэн ажлын тоо | Хийгдэж буй болон хойшлогдсон ажлын тоо |
|-----|------------------------------------------------------------|----------------------|-----------------------|-----------------------------------------|
| 1   | Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ                     | 22                   | 20                    | -                                       |
| 2   | Нөхөн сэргээлт                                             | 1                    | -                     | 1                                       |
| 3   | Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах арга хэмжээ | 1                    | -                     | 1                                       |
| 4   | Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээ         | Ажил төлөвлөөгүй.    | Ажил төлөвлөөгүй.     | -                                       |
| 5   | Түүх соёлын өвийг хамгаалах арга хэмжээ                    | Ажил төлөвлөөгүй.    | Ажил төлөвлөөгүй.     | -                                       |
| 6   | Осол эрсдэлийн менежмент                                   | 6                    | 6                     | -                                       |
| 7   | Хог хаягдлын менежмент                                     | 6                    | 6                     | -                                       |

|    |                                           |           |           |          |
|----|-------------------------------------------|-----------|-----------|----------|
| 9  | Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр        | 14        | 14        | -        |
| 10 | Удирдлага зохион байгуулалтын арга хэмжээ | 6         | 6         | -        |
| 11 | Олон нийтэд тайлагнах үйл ажиллагаа       | 1         | 1         | -        |
|    | <b>Нийт</b>                               | <b>57</b> | <b>55</b> | <b>2</b> |

## 5. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Төслийн үйл ажиллагаанаас үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах, түүнээс урьдчилан сэргийлэх үүднээс дараах арга хэмжээг бид хэрэгжүүлсэн.

Хүснэгт 9. Төслийн сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, арилгах, бууруулах арга хэмжээний биелэлт

| №                                                           | Байгаль орчныг хамгаалах арга хэмжээ                                                                                                                                                               | Хамрах хүрээ   | Ажлын гүйцэтгэл                                                                                                                                                                                                         | Нийт зардал /мян.төг/    |
|-------------------------------------------------------------|----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|----------------|-------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|--------------------------|
| Агаарын чанарт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах чиглэлээр |                                                                                                                                                                                                    |                |                                                                                                                                                                                                                         |                          |
| 1                                                           | Хуурайшилт ихтэй өдрүүдэд дотоод зам талбайн усалгаа                                                                                                                                               | Төслийн талбай | Хуурайшилт ихтэй өдрүүдэд тоосжилтыг бууруулах зорилгоор уурхайн дотоод тээвэрлэлтийн зам дагуу усалгааг өдөрт 2 удаагийн давтамжтайгаар услан сул тоос шороог дарах ажлыг хийсэн.                                      | Үйл ажиллагааны зардлаас |
| 2                                                           | Овоолтыг салхи ихтэй үед услах арга хэмжээ авах, тэдгээрийн гадаргууг ургамалжуулах                                                                                                                | Төслийн талбай | Хуурайшилт ихтэй өдрүүдэд тоосжилтыг бууруулах зорилгоор уурхайн дотоод тээвэрлэлтийн зам дагуу усалгааг өдөрт 1 удаа услан сул тоос шороог дарах ажлыг хийсэн.                                                         | Үйл ажиллагааны зардлаас |
| 3                                                           | Далд уурхайн агааржуулалтыг уурхайн хүдэр олборлох нэгдсэн дүрэмд нийцүүлэх, ажилчдын биеийн байдлыг хянах                                                                                         | Төслийн талбай | Өдөр бүр хөдөлмөрийн аюулгүй байдлын талаарх зааварчилгааг ажилчдад өгч ажигласан. Ажилчдыг эрүүл мэндийн үзлэгт хамруулах ажлыг зохион байгуулсан бөгөөд ажлын байран дээр анхан шатны тусламжийн хайрцаг байрлуулсан. | Үйл ажиллагааны зардлаас |
| 4                                                           | Ажлын байрны температур, чийглэг, гэрэлтүүлэг, шуугиан, агаарын чанар найрлага, цацрагийн хэмжээ зэргийг тодорхойлж дүгнэлт өгч сөрөг нөлөөллийг бууруулах технологийн арга хэмжээ авч хэрэгжүүлэх | Төслийн талбай | Ажлын байранд температур хэмжигч, чийглэгл тодорхойлогч зэрэг төхөөрөмжүүдийг байршуулсан бөгөөд хэмжилтийг тогтмол хянаж агаар сэлгэх, чийгшүүлэх зэрэг хариу арга хэмжээ авч ажигласан.                               | Үйл ажиллагааны зардлаас |

|   |                                                                                                                                              |                |                                                                                                                                                                                                                                                                                                                                |                          |
|---|----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|----------------|--------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|--------------------------|
| 5 | Уурхайн дотоод зам автомашинны хурдыг тохируулах аль болох бага байлгах                                                                      | Төслийн талбай | Уурхайн дотоод замд автомашины хурдны тохируулга бүхий тэмдэг, тэмдэглэгээг 3 ширхгийг шинэчлэн байршуулж ажилчдыг хурдны хязгаарт тохируулан ажиллах зааварчилгааг өдөр бүр өгөн үйл ажиллагаанд мөрдүүлэн ажилласан.                                                                                                         | 1.0                      |
